



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ  
**ХАНГАЙН НУРУУНЫ БАЙГАЛИЙН  
ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН  
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГАА**

65137 Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 3 дугаар баг,  
Утас: 7033 3179, И-мэйл: khangairange@mpa.gov.mn  
Вэб сайт: www.khangairange.mpa.gov.mn

2022.09.12 № 107

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

Санал хүргүүлэх тухай

Монгол Улсын Их сургууль, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийн Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхимийн 2022 оны хичээлийн жилд боловсруулсан “Байгаль хамгаалал ба тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент” хичээлийн хөтөлбөртэй танилцаж дараах саналыг хүргүүлж байна.

1. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны үйл ажиллагаа нь менежментийн төлөвлөгөөнд суурилж явагддаг ба “Байгаль хамгаалал ба тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент” хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөөнд биосфер дэх экосистемийн төрлүүд түүний үйлчилгээ, агаар, ус, хөрсний ашиглалт хамгаалал ба хог хаягдал, уур амьсгалын өөрчлөлт зэргийг холбон тусгасан байна. Энэ нь оюутан суралцагчдад тусгай хамгаалалттай газар нутгийн оновчтой менежментийн төлөвлөлт боловсруулах, байгаль орчинд учирч буй аюул дарамтыг үнэлэх, байгаль хамгааллын төлөвлөлтийн аргагүй, программ хангамжийг ашиглах чадвар, дадлыг эзэмших оновчтой төлөвлөлт байна.
2. “Байгаль хамгаалал ба тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент” хичээлийн хүрээнд судлагдах лекц болон семинарын хичээлүүдээр байгаль хамгааллын төлөвлөлт болон удирдлагын үндсэн ойлголт, тогтвортой хөгжлийн үндсэн зарчмууд, тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент, байгалийн нөөцийн ашиглалт болон хамгаалалт, уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэн буй орчны бохирдлын асуудлуудыг шийдвэрлэх зэрэг мэдлэгийг олж авахаар байна. Эдгээр мэдлэгийг олж авснаар тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны мэргэжилтэн байгаль хамгаалагчаар ажиллахад шаардлагатай мэдлэгийг бүрэн олж авах ач холбогдолтой байна. Иймд хичээлийн хөтөлбөр нь бидний хүний нөөцөө чадварлаг боловсон хүчнээр бүрдүүлэх, тэдгээрийн чадавхыг нэмэгдүүлэх ач холбогдол бүхий хичээлийн хөтөлбөр болсон гэж үзэж байна.

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  Д.БАТДЭЛГЭР

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, БАЙГАЛИЙН ЦОГЦ,  
МЭДЭЭЛЛИЙН САН ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  Ч.ИДЭРБАТ